



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/183

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай” 2018 оны 09/04 дүгээр тогтоол, Аймгийн 2019 оны төсөв батлах тухай 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд зохион байгуулах “Зорилтот жилийн нээлт”-ийн үйл ажиллагааны зардлыг нэгдүгээр, “Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, баг, байгууллага аж ахуйн нэгж, айл өрхийг шалгаруулах болзолт уралдааны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, баг, байгууллага аж ахуйн нэгж, айл өрхийг шалгаруулах болзолт уралдааны бэлтгэлийг хангаж, өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хороо (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах 28.550.740 (хорин найман сая таван зуун тавин мянга долоон зуун дөч) төгрөгийн зардлыг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100412

Аймгийн Засаг даргын 2019 оны 03  
дугаар сарын 20 ны өдрийн 1/182 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ЗОРИЛТОТ ЖИЛИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Нээлтийн ажлын анонс	12м <sup>2</sup>	7000	84000
2	Зорилтот жилийн лого, шторк	1ш	100000	100000
3	Шаар	5	8000	40000
4	Зорилтот жилийн 2 талтай туг	3ш	70000	210000
5	Зорилтот жилийн дарцаг	100ш	3000	300000
6	Гадна байрлуулах анонс	239,4м <sup>2</sup>	9000	2154240
7	Фото стикер-а/3	1000ш	850	850000
8	Гадуур анонас тогтоох олс	500м	600	300000
9	Шаар үлээгч	5	2500	12500
<b>Бүгд</b>				<b>4050740</b>

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн 1182 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“ШИЛДЭГ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ СУМ, БАГ, БАЙГУУЛЛАГА АЖ АХУЙН НЭГЖ, АЙЛ ӨРХИЙГ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ЗАРДАЛ

Шилдэг тохижилт ногоон байгууламжтай сум

д/д	Байр	Тоо	Шагналын хэмжээ /₮/
1	1 дүгээр байр	1	3000000
2	2 дугаар байр	1	2000000
3	3 дугаар байр	1	1000000
Дүн			<b>6000000</b>

Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай баг

д/д	Байр	Тоо	Шагналын хэмжээ /₮/
1	1 дүгээр байр	1	2000000
2	2 дугаар байр	1	1500000
3	3 дугаар байр	1	1000000
Дүн			<b>4500000</b>

Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай байгууллага, аж ахуйн нэгж

д/д	Байр	Тоо	Шагналын хэмжээ /₮/
1	1 дүгээр байр	1	2000000
2	2 дугаар байр	1	1500000
3	3 дугаар байр	1	1000000
Дүн			<b>4500000</b>

Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай айл өрх

д/д	Байр	Тоо	Шагналын хэмжээ /₮/
1	Шилдэг айл өрх /сум тус бүрээс 1 өрхийг шалгаруулна	19	500000
Дүн			<b>9500000</b>
Бүгд			<b>24500000</b>